



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/103

Алтай хот

Малын сэг зэмийг устгах, ариутгал
халдваргүйтгэлийн ажлыг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 7.3.3 дахь заалт, 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд малын сэг зэмийг устгах, ариутгал халдваргүйтгэлийн ажлыг 2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 01-ний өдрийн хооронд чанартай зохион байгуулсугай.

2.Сумд харьяалах нутаг дэвсгэртээ хорогдсон мал амьтны сэг зэмийг цуглуулан устгах, халдваргүйтгэл хийхэд шаардагдах ажиллах хүч, унаа тээвэр шатахуун зэрэг шаардлагатай бусад зардлыг шийдвэрлэж, орон нутгийн байгууллага, малчдыг оролцуулах олон нийтийн санал санаачилгыг дэмжин ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Аймгийн хэмжээнд мал, амьтны сэг зэмийг устгах, орчны цэвэрлэгээ ариутгал, халдваргүйтгэлийн төлөвлөгөө гаргаж, нэгдсэн удирдамжаар хангах, чанар аюулгүйн шаардлага хангасан ариутгал халдваргүйтгэлийн бодис, биобэлдмэлийн нөөц бүрдүүлэн хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Д.Наянбуу)-т үүрэг болгосугай.

4.Төв суурин газар, улс, аймгийн чанартай авто зам, малын бэлчээр, гол, булаг шандны орчмын малын сэг зэмийг цуглуулж, булж устгах, ажлыг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулж хэвшихийг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

5.Ажлын үр дүнг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор тайлагнахыг Мал эмнэлгийн газар (Д.Наянбуу)-т даалгасугай.

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Хурцгэрэл)-т даалгасугай.

ОРЛОГЧ

Г.ЧИНБАТ